

Аудитын код: САГ-2017/44/80-БСД

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 262451, 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж

Утас: 261740, 99027789 Цахим хаяг: tserendorj@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.10	Шилэн дансны мэдээлэл	9
2.11	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
3.1	Сургалт семинарын зардал	11
	Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил	12
	дутагдлыг төсвийн захирагч хүлээн	12
	зөвшөөрсөн болно.	12
3.2	Цалин, шагнал урамшуулал	13
3.3	Төсвийн гүйцэтгэл	14

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах

УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
10100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV багц,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

2017.02.20 № 3/247
Тайлан - ны № -Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн
8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын
аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн
санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн
тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппарат нь Төсвийн тухай
хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг
Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай
хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон
улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар,
журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн
аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын
Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу
гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг
буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор
аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон
илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого,
бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох
зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж
цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт
итгэлтэй байна.

010.10.10.20/Bichig_Kheregi/Yawsan_Bichig/2017/0220SAG47Docx

070215

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт –д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 2 дугаар сарын 2–ноос 2 дугаар сарын 7– ны хооронд хийж, аудитын тайланг 2 дугаар сарын 7- ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 1 дүгээр сарын 25- ны өдөр төрийн аудитын байгууллагад 2017оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/126 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 –1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжинд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгал нь нэг талаас аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтныхаа нийгмийн хамгааллыг хангах нөхцөл болдог, нөгөө талаас даатгуулагч иргэний амьдралынхаа бүхий л үеийн туршид тухайлбал: хөдөлмөрлөх явцдаа болон өвдөх, жирэмслэх, хүүхэд төрүүлэх, осолд орох, ажилгүй болох, өндөр наслах, тахир дутуу болох тохиолдлуудад орлогогүй буюу орлого нь буурсан нөхцөлд нийгмийн баталгааг нь хангадаг.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцлаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд өөрийн байгууллагын санхүүгийн программ хангамж ашиглажээ.

Тус байгууллагын нэгтгэл хийгддэг нэгдсэн санхүүгийн программыг хангалттай гэж дүгнэж байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл өндөр эрсдэлтэй гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 12 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын дүнг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь илүү бодитой гарах магадлалтай юм.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,744.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 74,8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь илүү бодитой илэрхийлэгдэх юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 4 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 60 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	177.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	3	177.9	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд

3,026.23 сая төгрөг, хөрөнгийн зардалд 285.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3.311.23	2,706.73	81.7	604.5
1.1	Урсгал зардал	3,026.23	2,421.91	80	604.3
1.2	Хөрөнгийн зардал	285.0	284.82	99.9	0.2

Төсөвт зардлын гүйцэтгэл 81.7 хувьтай байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.10 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

2.11 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 СУРГАЛТ СЕМИНАРЫН ЗАРДАЛ

Илрүүлэлт

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 105.4 сая төгрөгийн сургалт семинарыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2016 оны 4 дүгээр сард удирдах ажилтны зөвлөгөөнийг 30.3 сая төгрөгөөр Тэрэлж амралтын газарт зохион байгуулсан.
- 3 дугаар сард сумдын нийгмийн даатгалын байцаагчдын анхдугаар зөвлөлгөөнийг 61.8 сая төгрөгөөр Сэлэнгэ аймагт зохион байгуулсан байна.
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан байцаагч нарт хуулийн өөрчлөлтийг сурталчлах сургалтыг Улаанбаатар хотод 8.9 сая төгрөгөөр зохион байгуулжээ.
- Шинээр томилогдсон ажилтнуудад нийгмийн даатгалын тухай хуулийн мэдлэг олгох сургалтыг Улаанбаатар хотод 4.4 сая төгрөгөөр тус тус зохион байгуулжээ.

Тайлант онд төслийн хөрөнгөөр 36.8 сая төгрөгийн сургалт семинарыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Мөн оны 10 дугаар сард бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг сумдын нийгмийн даатгалын байцаагчдыг чадавхижуулах сургалтыг 14.7 сая төгрөгөөр, 12 дугаар сард бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, ач холбогдолыг ойлгуулах сургалтыг 11 аймагт 17.3 сая төгрөгөөр тус тус зохион байгуулжээ.
- Нийслэл, дүүргүүдийн орлого бүрдүүлэлтийн байцаагчдын сургалтанд 4.8 сая төгрөг зарцуулсан.

Зөвлөмж

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д " Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 7-д "хурал, сургалт, зөвлөгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Газрын дарга Д.Зоригт
Ерөнхий нягтлан бодогч Ц. Наранцэцэг

Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулах, төсвийг үр ашиггүй зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Цалин, шагнал урамшуулал

Илрүүлэлт

2016 оны 8-10 дугаар сард шинээр ажилд орсон 33 хүнд үр дүнгийн урамшууллыг бүтэн жил ажилласнаар тооцож сарын үндсэн цалинг 80-100 хувиар бодож нийт 12.2 сая төгрөг олгосон нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр үр чадвар, идэвх санаачлага гарган албан үүргээ тогтмол чанартай сайн биелүүлж ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж албан хаагчид улирлын үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 96 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Хариуцах ажилтан

Газрын дарга Д.Зоригт
Ерөнхий нягтлан бодогч Ц. Наранцэцэг

Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулах, төсвийг үр ашиггүй зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Төсвийн гүйцэтгэл

Илрүүлэлт

Тайлант онд Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2,421.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 604.3 сая төгрөг хэмнэж ажилласан боловч унаа хоолны нөхөн олговорыг 22.0 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 1.4 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэгийг 0.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь Сангийн сайдын 2013 оны "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай" 73 дугаар тушаалаар батлагдсан журмын 8 дугаар зүйлийн 8.1-д "Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж

Сангийн сайдын "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай" 73 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах.

Хариуцах ажилтан

Газрын дарга Д.Зоригт
Ерөнхий нягтлан бодогч Ц. Наранцэцэг

Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	951,882,401.90	193,183,805.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	77,573,505.69	66,451,361.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	77,573,505.69	66,451,361.39
3121	Төгрөг	77,573,505.69	66,451,361.39
31211	Төрийн сангийн харилцах	77,573,505.69	66,451,361.39
33	АВЛАГА	45,071,559.20	36,759,506.20
335	Бусад авлага	45,071,559.20	36,759,506.20
3351	Байгууллагаас авах авлага	11,087,415.20	10,477,587.20
3352	Хувь хүмүүсээс авах авлага	33,984,144.00	26,281,919.00
34	УРЬДЧИЛГАА	735,584,617.50	1,177,284.50
3471	Урьдчилгаа тооцоо	735,584,617.50	1,177,284.50
34713	Цалингийн урьдчилгаа	735,584,617.50	1,177,284.50
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	93,652,719.51	88,795,652.91
354	Хангамжийн материал	93,652,719.51	88,795,652.91
35410	Бичиг хэргийн материал	13,232,078.60	9,847,482.00
35420	Аж ахуйн материал	79,179,850.91	77,797,281.91
35430	Сэлбэг хэрэгсэл	1,240,790.00	1,150,889.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,295,464,620.00	6,556,553,338.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,295,464,620.00	6,556,553,338.77
391	Газар		
392	Биет хөрөнгө	6,260,792,961.00	6,531,040,688.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,489,776,748.77	5,575,802,255.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(359,838,135.73)	(455,009,544.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	258,460,000.00	438,420,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(145,624,405.95)	(204,005,183.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	795,037,833.11	1,033,742,121.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(193,088,486.33)	(331,943,667.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	529,238,412.48	639,438,312.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(113,169,005.35)	(165,403,605.98)
393	Биет бус хөрөнгө	34,671,659.00	25,512,650.50
39301	Програм хангамж	21,174,248.00	21,174,248.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(19,178,623.00)	(20,168,623.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,676,034.00	32,676,034.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(8,169,008.50)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,247,347,021.90	6,749,737,143.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	59,151,794.49	15,326,514.29

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	59,151,794.49	15,326,514.29
41320	Өглөг	59,151,794.49	15,326,514.29
41330	Ажилчидтай холбогдсон өглөг	(33,277,922.70)	4,822,110.10
41362	Бусад өглөг	92,429,717.19	10,504,404.19
41363	Байгууллагад төлөх өглөг	92,429,717.19	10,504,404.19
511	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,188,195,227.41</u>	<u>6,734,410,629.48</u>
51101	Засгийн газрын хувь оролцоо	7,188,195,227.41	6,734,410,629.48
51102	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,071,112,537.98	2,071,112,537.98
51103	Өмч: - төрийн		
51104	- хувийн		
51105	- хувьцаат		
51106	Халаасны хувьцаа		
512	Нэмж төлөгдсөн капитал		
51210	Эздийн өмчийн бусад хэсэг		
51220	Хуримтлагдсан үр дүн	4,466,793,924.61	4,013,009,326.68
51230	Өмнөх үеийн үр дүн	4,466,793,924.61	4,433,419,040.81
51300	Тайлант үеийн үр дүн		(420,409,714.13)
51400	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51500	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	650,288,764.82	650,288,764.82
51600	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
6	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
	Нөөцийн сан		
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,247,347,021.90</u>	<u>6,749,737,143.77</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,560,142,358.98	3,346,301,297.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	693,492,124.98	291,239,584.00
120	Нийтлэг татварын бус орлого	693,492,124.98	291,239,584.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	693,492,124.98	291,239,584.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	693,492,124.98	291,239,584.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,866,650,234.00	3,055,061,713.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,866,650,234.00	3,055,061,713.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,797,499,100.00	2,705,503,029.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		64,729,370.70
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх □		
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,069,151,134.00	284,829,314.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,004,594,092.16	3,744,197,718.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,004,594,092.16	3,744,197,718.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,648,441,937.43	3,240,592,759.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,556,838,127.96	1,560,921,024.00
210101	Үндсэн цалин	1,287,068,141.96	1,241,139,541.00
210102	Нэмэгдэл	269,769,986.00	319,781,483.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,846,036.09	171,235,984.99
210201	Тэтгэврийн даатгал	95,302,078.51	108,906,086.46
210202	Тэтгэмжийн даатгал	10,938,760.58	12,500,226.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,635,989.92	15,582,474.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,697,228.64	3,082,247.73
210205	Эрүүл мэндийн даатгал	27,271,978.44	31,164,949.27
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,993,900.98	37,533,379.00
210301	Гэрэл, цахилгаан	27,274,719.00	21,762,694.00
210302	Түлш, халаалт	7,510,249.00	9,944,485.00
210303	Цэвэр, бохир ус	1,874,131.00	5,826,200.00
210304	Байрны түрээс	78,334,801.98	
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	1,033,324,785.81	728,479,412.60
210401	Бичиг хэрэг	29,350,998.96	22,976,424.60
210402	Тээвэр, шатахуун	23,660,257.73	10,279,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,149,282.12	27,174,025.00
210404	Ном, хэвлэл	3,863,020.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,730,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	939,301,227.00	666,319,463.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,020,824.39	37,162,984.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,475,400.00	1,033,900.00
210602	Тавилга	52,669,734.39	27,755,235.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	15,875,690.00	8,373,849.00
2107	Томилдолт, зочны зардал	98,172,185.88	38,634,129.00

210701	Гадаад албан томилолт	45,048,025.88	
210702	Дотоод албан томилолт	53,124,160.00	38,634,129.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,782,576.74	218,869,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	4,842,342.77	4,550,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		645,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,897,999.52	63,024,224.00
210807	Газрын төлбөр	819,104.00	5,050,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,613,301.45	874,400.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	174,609,829.00	144,725,616.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,463,499.58	447,756,165.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	123,423,286.00	91,114,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	188,040,213.58	356,641,255.41
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	356,152,154.73	503,604,959.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,876,010.00	192,777,819.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	85,715,176.00	66,399,019.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	879,800.00	880,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,426,200.00	74,634,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан үзэгчид төрөөс үзэмлэх тэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,854,834.00	50,864,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,276,144.73	310,827,140.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,276,144.73	310,827,140.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	555,548,266.82	(397,896,420.30)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,817,906.10	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,817,906.10	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,536,115.44	22,513,293.82
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,266,338.00	22,513,293.82
225002	Найдваргүй авлагын алдагдал		
225003	Хөрөнгө оруулалтын гарз		
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	12,269,777.44	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(14,718,209.34)	(22,513,293.82)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	540,830,057.48	(420,409,714.12)

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,483,832,422.54	3,068,440,039.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	617,182,188.54	13,378,326.00
120	Нийтлэг татварын бус орлого	617,182,188.54	13,378,326.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,970,471.08	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,970,471.08	
120009	Бусад орлого	611,211,717.46	13,378,326.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,866,650,234.00	3,055,061,713.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,866,650,234.00	3,055,061,713.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,797,499,100.00	2,705,503,029.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		64,729,370.70
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх □		
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,069,151,134.00	284,829,314.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,476,818,501.41	2,794,732,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,476,818,501.41	2,794,732,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,119,350,785.68	2,291,127,911.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,573,211,885.01	1,563,223,455.00
210101	Үндсэн цалин	1,494,369,385.01	1,477,987,455.00
210102	Нэмэгдэл	78,842,500.00	85,236,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,815,937.65	168,935,678.00
210201	Тэтгэврийн даатгал	94,646,936.35	107,443,091.21
210202	Тэтгэмжийн даатгал	10,863,563.45	12,332,304.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,542,250.33	15,373,146.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,678,686.87	3,040,842.20
210205	Эрүүл мэндийн даатгал	27,084,500.65	30,746,293.40
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,993,900.98	37,533,379.00
210301	Гэрэл, цахилгаан	27,274,719.00	21,762,694.00
210302	Түлш, халаалт	7,510,249.00	9,944,485.00
210303	Цэвэр, бохир ус	1,874,131.00	5,826,200.00
210304	Байрны түрээс	78,334,801.98	
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	77,693,749.91	58,775,353.00
210401	Бичиг хэрэг	24,506,190.06	19,591,828.00

210402	Тээвэр, шатахуун	12,175,257.73	10,279,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,149,282.12	27,174,025.00
210404	Ном, хэвлэл	3,863,020.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,730,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,128,104.84	31,777,014.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,225,390.00	943,999.00
210602	Тавилга	24,027,024.84	22,459,166.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	5,875,690.00	8,373,849.00
2107	Томилолт, зочны зардал	98,714,185.88	38,634,129.00
210701	Гадаад албан томилолт	45,048,025.88	
210702	Дотоод албан томилолт	53,666,160.00	38,634,129.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	947,369,735.41	301,133,993.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	4,842,342.77	4,550,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		645,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,897,999.52	63,024,224.00
210807	Газрын төлбөр	819,104.00	5,050,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,613,301.45	874,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	626,317,381.23	82,264,313.00
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/		
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	186,879,606.44	144,725,616.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,423,286.00	91,114,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	123,423,286.00	91,114,910.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	357,467,715.73	503,604,959.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,191,571.00	192,777,819.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,074,542.00	14,978,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	879,800.00	880,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,426,200.00	74,634,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,811,029.00	102,284,669.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,276,144.73	310,827,140.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,276,144.73	310,827,140.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,007,013,921.13</u>	<u>273,707,169.70</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,069,151,134.00	284,829,314.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,069,151,134.00	284,829,314.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,069,151,134.00	284,829,314.00
220001	Барилга байгууламж	41,126,193.00	54,899,314.00
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж	915,700,140.00	
223001	Бусад хөрөнгө	79,648,767.00	229,930,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	32,676,034.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,069,151,134.00)	(284,829,314.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(62,137,212.87)	(11,122,144.30)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	139,710,718.56	77,573,505.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,573,505.69	66,451,361.39

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,071,112,537.97	650,288,764.82	3,895,780,456.60		6,617,181,759.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,071,112,537.97	650,288,764.82	3,895,780,456.60	0.00	6,617,181,759.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			571,013,468.01		571,013,468.01
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,071,112,537.97	650,288,764.82	4,466,793,924.61	0.00	7,188,195,227.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-33,374,883.80		-33,374,883.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,071,112,537.97	650,288,764.82	4,433,419,040.81	0.00	7,154,820,343.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-420,409,714.13		-420,409,714.13
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,071,112,537.97	650,288,764.82	4,013,009,326.68	0.00	6,734,410,629.47

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,311,216,500.00	2,706,743,457.60	604,473,042.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,026,216,500.00	2,421,914,143.60	604,302,356.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,831,232,300.00	2,229,136,324.60	602,095,975.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,958,813,700.00	1,612,296,182.00	346,517,518.00
210101	Үндсэн цалин	1,818,438,700.00	1,498,260,182.00	320,178,518.00
210102	Нэмэгдэл	63,165,800.00	85,236,000.00	(22,070,200.00)
210105	Гэрээт ажлын хөлс	77,209,200.00	28,800,000.00	48,409,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,574,100.00	168,935,677.60	76,638,422.40
210201	Тэтгэврийн даатгал	156,594,600.00	107,443,091.21	49,151,508.79
210202	Тэтгэмжийн даатгал	17,796,100.00	12,332,304.49	5,463,795.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,244,800.00	15,373,146.70	6,871,653.30
210204	Ажилгүйдлийн даатгал	4,448,800.00	3,040,842.20	1,407,957.80
210205	Эрүүл мэндийн даатгал	44,489,800.00	30,746,293.00	13,743,507.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,598,800.00	37,533,379.00	102,065,421.00
210301	Гэрэл, цахилгаан	41,251,900.00	21,762,694.00	19,489,206.00
210302	Түлш, халаалт	15,593,300.00	9,944,485.00	5,648,815.00
210303	Цэвэр, бохир ус	8,713,900.00	5,826,200.00	2,887,700.00
210304	Байрны түрээс	74,039,700.00	-	74,039,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,844,300.00	81,234,519.00	7,609,781.00
210401	Бичиг хэрэг	28,295,700.00	19,591,828.00	8,703,872.00
210402	Тээвэр, шатахуун	8,865,800.00	10,279,500.00	(1,413,700.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,629,000.00	27,174,025.00	454,975.00
210404	Ном, хэвлэл			-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	745,900.00	1,730,000.00	(984,100.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,307,900.00	22,459,166.00	848,734.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,749,700.00	9,317,848.00	4,431,852.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,047,400.00	943,999.00	3,103,401.00
210604	Урсгал засвар	9,702,300.00	8,373,849.00	1,328,451.00
2107	Томилолт, зочны зардал	41,388,900.00	38,634,129.00	2,754,771.00
210701	Гадаад албан томилолт			-
210702	Дотоод албан томилолт	41,388,900.00	38,634,129.00	2,754,771.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,857,200.00	189,862,740.00	50,994,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-
210803	Даатгалын үйлчилгээ	5,840,800.00	4,550,240.00	1,290,560.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	645,200.00	645,200.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,500,000.00	63,024,224.00	2,475,776.00
210807	Газрын төлбөр	5,050,000.00	5,050,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000,000.00	874,400.00	9,125,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	153,821,200.00	115,718,676.00	38,102,524.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,405,600.00	91,321,850.00	11,083,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,366,600.00	206,940.00	11,159,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,039,000.00	91,114,910.00	(75,910.00)

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,984,200.00	192,777,819.00	2,206,381.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	194,984,200.00	192,777,819.00	2,206,381.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж			-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж			-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,000,000.00	14,978,350.00	21,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,864,000.00	50,864,000.00	-
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	885,600.00	880,200.00	5,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,634,600.00	74,634,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,600,000.00	51,420,669.00	2,179,331.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	285,000,000.00	284,829,314.00	170,686.00
2200	Дотоод эх үүсвэрээр	285,000,000.00	284,829,314.00	170,686.00
220001	Барилга байгууламж		54,899,314.00	(54,899,314.00)
221001	Их засвар			-
222001	Тоног төхөөрөмж			-
223001	Бусад хөрөнгө	285,000,000.00	229,930,000.00	55,070,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө			-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр			-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл			-
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл			-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл			-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,311,230,500.00	2,990,332,343.00	320,898,157.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,311,230,500.00	2,990,332,343.00	320,898,157.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,311,230,500.00	2,990,332,343.00	320,898,157.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих			-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-
131008	Хөрөнгийн			-